



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/192

Чойр

Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын
улсын үзлэг явуулах, албан татвар,
төлбөр хураах тухай


Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.16, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Зам, тээврийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/199 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоо явуулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэгийг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Автотээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар, орон нутгийн авто зам ашигласны төлбөр хураамжийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг Татварын хэлтэс (П.Энх-Оюун)-т, тээврийн хэрэгслийн улсын дугаар солих, шилжилт хөдөлгөөн, хасалт хийх, техникийн хяналтын суурин болон явуулын үзлэгийг хуваарийн дагуу зохион байгуулахыг Говьсүмбэр аймгийн Автотээврийн төв (Н.Мөнхнаран)-д, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн тасаг (Ш.Билэгбадмарал)-т, харъяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг хуваарийн дагуу автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулж, зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нар, аж ахуй нэгж байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйлчилгээнд аймгийн Төрийн санд бүртгэлтэй орон нутагт үйл ажиллагаа явуулах эрхтэй даатгалын компаниуд, Татварын хэлтэс, Автотээврийн үндэсний төвөөс үзүүлэх үйлчилгээг нэг цэгт төвлөрүүлэн, иргэдэд үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай зохион байгуулж, үзлэгийн үр дүнг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэг (Г.Хонгор)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4212400216

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 04 -ны өдрийн 492 дугаар захиармжийн 1-р хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ, АЛБАН
ТАТВАР, ТӨЛБӨР ХУРААХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Г.Хонгор
(АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Гишүүд:

П.Энх-Оюун
(Говьсүмбэр аймгийн Татварын хэлтсийн дарга)

Ш.Билэгбадмарал
(Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн тасгийн дарга)

Т.Бат-Эрдэнэ
(Сүмбэр сумын Засаг дарга)


Ч.Сугармаа
(Шивээговь сумын Засаг дарга)

Б.Ганбаяр
(Баянтал сумын Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:

Н.Мөнхнаран
(Говьсүмбэр аймгийн Автотээврийн төвийн дарга)

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 49 дугаар захиармжийн 2-р хавсралт



ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН 2024 ОНЫ
ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ
ХУВААРЬ

№	Байгууллага аж ахуйн нэгж, сумдын нэр	Хугацаа	Техникийн хяналтын үзлэг явуулах газар.
1	Нефть хангамжийн газрууд	04 дүгээр сарын 04-05	Автотээврийн төвд
2	"Ус-Ду" ОНӨҮГ, Полтехникийн коллеж, "Тохижилт сүмбэр" ОНӨҮГазар	04 дүгээр сарын 08	Автотээврийн төвд
3	"Цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн Говьсүмбэр салбар, "Цахилгаан дамжуулах станц" ТӨХК-ийн Говьсүмбэр салбар	04 дүгээр сарын 09-10	Автотээврийн төвд
4	Улаанбаатар төмөр замын харъяа байгууллагууд /Чойр өртөө, Худалдааны төв, ТЗ-ын цахилгаан холбоо, ТЗ-ын гал унтраах анги, Барилга орон сууцны 2-р анги, Замын 3-р анги/	04 дүгээр сарын 11-12	Автотээврийн төвд
5	Онцгой байдлын хэлтэс, Улсын нөөцийн газар, Цагдаагийн хэлтэс, Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Прокурор, Тагнуулын тасаг	04 дүгээр сарын 15-17	Автотээврийн төвд
6	Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Хаан банк, Хас банк, Төрийн банк, Цахилгаан холбооны газар, "Шуудан холбооны газар" ТӨХК	04 дүгээр сарын 18-19	Автотээврийн төвд
7	Аймгийн ЗДТГ, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Сүмбэр сумын ЗДТГ, Боловсрол соёлын газар, Аудитын газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Татварын хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлэгийн газар, Улсын бүртгэлийн газар, Цаг уурын орчины шинжилгээний газар, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа	04 дүгээр сарын 22-23	Автотээврийн төвд

8	Биеийн тамир спорт хороо, Боржигон чуулга, Боржигин өв музей, Даатгалын компаниуд	04 дүгээр сарын 24	Автотээврийн төвд
9	"Баян нексус" ХХК, Дэлхийн зөн ОУБ, Улаан загалмайн нийгэмлэг,	04 дүгээр сарын 25	Автотээврийн төвд
10	Шивээговь сум	04 дүгээр сарын 29-30 05 дугаар сарын 01	Тухайн суманд
11	Баянтал сум	05 дугаар сарын 02	Тухайн суманд
12	Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа эрхэлж байгаа болон бусад ашигт малтмал тээвэрлэгч компаниуд	05 дугаар сарын 06-17	Тухайн газарт
13	Сүмбэр сумын 4-р баг	05 дугаар сарын 20	Баг дээр
14	Сүмбэр сумын 5-р баг	05 дугаар сарын 21	Баг дээр
15	Сүмбэр сумын 6-р баг	05 дугаар сарын 22	Баг дээр
16	Сүмбэр сум 1-р баг	05 дугаар сарын 23-31	Автотээврийн төвд
17	Сүмбэр сум 2-р баг	06 дугаар сарын 3-14	Автотээврийн төвд
18	Сүмбэр сум 3-р баг	06 дугаар сарын 17-28	Автотээврийн төвд
19	Хяналтын хугацаа, бусад тээврийн хэрэгсэлүүд	07 дугаар сарын 01-ээс 30-ныг дуустал	Автотээврийн төвд
20	Шивээговь сум	09 дүгээр сарын 16-17	Автотээврийн төвд